



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТАРАГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/01

Тарагт сум

Цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 34 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. 2024 оны Цэргийн бүртгэлийн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 01 дүгээр сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд бүх багт биечлэн болон цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Цэргийн бүртгэл явуулах ажлын хэсгийг хавсралтаар баталж, бэлтгэл ажлыг ханган зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батцэцэг), багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Иргэдэд 2024 оны Цэргийн бүртгэлийг цахим хэлбэрээр бүртгэх талаарх мэдээлэл зөвлөгөө өгөх, цахим оператор горимоор үйлчилгээ үзүүлэх ажлыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Б.Саруул)-д даалгасугай.

4. Цэргийн бүртгэлийг үнэн зөв явуулж, тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батцэцэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

20100001

D My doc Zahiramj Zasag darga